ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

# АШУҮИС-ийн Говь-Алтай аймаг дахь салбар Анагаах ухааны сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ГАА-2026/179/НА-СТА-ТШЗ



| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Алтай хот<br>2026 он | Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа<br>Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn<br>Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг<br>Утас: 99175677 Цахим хаяг:erdenechimegd@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Д.Цэрэнханд<br>Утас: 99086371 Цахим хаяг:atartsetsegm@audit.gov.mn<br>Аудитор: Н.Гэрэлмаа<br>Утас: 99782918 Цахим хаяг:gerelmaan@audit.gov.mn |



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** .......... 2
**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** .......... 3
**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан** (төгрөгөөр) . 3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр) .. 4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр) .... 5
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр) ....... 6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр) ....... 7
**Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** .......... 9
3.1 Залруулсан алдаа: .......... 9
3.2 Зөвлөмж .......... 9
**Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** .......... 12



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2026. 02. 25 № 111

танай ____________ -ны № ____________ -т

АШУҮИС-ИЙН ГОВЬ-АЛТАЙ
АЙМАГ ДАХЬ АНАГААХ УХААНЫ
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Д.ГҮНДЭГМАА
ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу АШУҮИС-ийн Говь-Алтай аймаг дахь салбар Анагаах ухааны сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Байгууллагад нам даралтын 86,812.0 мянган төгрөгийн зуух худалдан авахдаа худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2, 16 дугаар зүйлийн 16.5.4, 24 дүгээр зүйлийн 24.4, 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгтэй тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

82250S000339

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант онд тус сургууль нь дээд боловсролын болон төгсөлтийн өмнөх сургалтын 14 хөтөлбөрөөр 482 оюутан шинээр элсүүлсэн бөгөөд 1005 оюутан суралцаж байна. Оюутны дотуур байранд 252 оюутан амьдарч байна.

Хичээлийн байрны халаалтын зардлыг хэмнэх зорилгоор хичээлийн байранд нам даралтын уурын зуухыг шинээр барьж ашиглалтад оруулсан, Ундарга-Алтай ААТҮГ-тай байгуулсан гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж цэвэр, бохир усны үнийг бууруулсан байна.

Хүний их эмч бакалавр, эм найруулагч дэд бакалавр, лабораторийн дэд баклаврын хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 3,662,542.8 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлэхээр төлөвлөсөн боловч 972,102.8 мянган төгрөгөөр тасарсан байна. Үүнд Боловсролын зээлийн сангаас санхүүжих 785,515.8 мянган төгрөгийн орлого байна.

АШУҮИС-ийн Говь-Алтай аймаг дахь салбар Анагаах ухааны сургуулийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,082,698.5 мянган төгрөгөөр буюу 29.9 хувиар, нийт зардал 267,421.1 мянган төгрөгөөр буюу 8.1 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Тайланд онд цалин 10.0 хувиар нэмэгдсэн, үйл ажиллагааны орлого 972,102.8 мянган төгрөгөөр тасарсан, 2025-2026 оны хичээлийн жилийн Боловсролын зээлийн сангаас санхүүжих 785,515.8 мянган төгрөгийн сургалтын төлбөрийн орлого хугацаандаа төвлөрөөгүй зэргээс шалтгаалан 513,230.5 мянган төгрөгийн өр үүссэний 367,848.8 мянган төгрөг нь урьдчилж олгосон орлого байна.

**Бусад асуудал**

АШУҮИС-ийн ректортой байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 3 зорилт, 29 арга хэмжээний хэрэгжилтийг 96.7 хувиар үнэлсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Г.ГҮНЖИДМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **445,108,343.39** | **584,114,619.65** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 100,329,823.39 | 8,773,977.35 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 100,329,823.39 | 8,773,977.35 |
| **3121** | **Төгрөг** | 100,329,823.39 | 8,773,977.35 |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | 100,329,823.39 | 8,773,977.35 |
| **33** | **АВЛАГА** | 233,905,811.00 | 429,814,213.30 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 217,616,411.00 | 429,814,213.30 |
| **335** | **Бусад авлага** | 16,289,400.00 | - |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 16,289,400.00 | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 110,872,709.00 | 145,526,429.00 |
| **351** | **Түүхий эд материал** | 61,593,219.00 | 65,463,939.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 61,593,219.00 | 65,463,939.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 49,279,490.00 | 80,062,490.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 49,279,490.00 | 80,062,490.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **6,310,138,687.64** | **6,169,658,139.75** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 6,310,138,687.64 | 6,169,658,139.75 |
| **392** | **Биет хөрөнгө** | 5,856,038,687.64 | 5,715,558,139.75 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 6,181,283,738.48 | 6,179,775,326.78 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (898,879,235.46) | (1,020,452,152.92) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 43,338,479.22 | 42,565,179.22 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (35,854,810.60) | (36,842,373.80) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 929,943,778.40 | 823,075,085.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (753,719,550.02) | (624,114,189.20) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 487,054,035.12 | 403,618,499.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (316,254,578.50) | (274,446,065.33) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 1,800,000.00 | 1,800,000.00 |
| 39217 | Ном | 217,326,831.00 | 220,578,831.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 454,100,000.00 | 454,100,000.00 |
| 39301 | Програм хангамж | 17,775,000.00 | 5,000,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (17,775,000.00) | (5,000,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 454,100,000.00 | 454,100,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **6,755,247,031.03** | **6,753,772,759.40** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **14,214,222.71** | **513,230,457.60** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 14,214,222.71 | 513,230,457.60 |
| **413** | **Өглөг** | 14,214,222.71 | 145,381,617.60 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 14,214,222.71 | 140,678,617.60 |
| **4136** | **Бусад өглөг** | - | 4,703,000.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 4,703,000.00 |
| **414** | **Урьдчилж орсон орлого** | - | 367,848,840.00 |
| 41420 | Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого | - | 367,848,840.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **6,741,032,808.32** | **6,240,542,301.80** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 6,741,032,808.32 | 6,240,542,301.80 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,074,027,102.40 | 1,074,027,102.40 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,074,027,102.40 | 1,074,027,102.40 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 4,343,508,421.81 | 3,867,497,450.51 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 4,028,721,493.46 | 4,367,987,957.03 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 314,786,928.35 | (500,490,506.52) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,323,497,284.11 | 1,299,017,748.89 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **6,755,247,031.03** | **6,753,772,759.40** |

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **3,619,137,472.04** | **2,536,438,927.86** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **3,430,910,472.04** | **2,536,438,927.86** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 3,430,910,472.04 | 2,536,438,927.86 |
| 120002 | Хүүгийн орлого | 2,025,630.03 | 1,726,734.86 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 3,425,334,842.01 | 2,531,362,193.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,160,925,897.00 | 2,250,741,858.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 264,408,945.01 | 280,620,335.00 |
| 120009 | Бусад орлого | 3,550,000.00 | 3,350,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **188,227,000.00** | **-** |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 188,227,000.00 | - |
| 133001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 188,227,000.00 | - |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **3,304,350,543.69** | **3,036,929,434.38** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **3,304,350,543.69** | **3,036,929,434.38** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 3,252,010,543.69 | 2,976,393,934.38 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,852,709,666.35 | 1,861,881,584.61 |
| 210101 | Үндсэн цалин | 1,428,596,737.63 | 1,425,250,744.12 |
| 210102 | Нэмэгдэл | 299,152,928.72 | 311,940,840.49 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 124,960,000.00 | 124,690,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 228,030,676.25 | 224,620,372.26 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 228,030,676.25 | 224,620,372.26 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 565,052,220.04 | 393,733,501.89 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 64,514,026.91 | 101,732,362.38 |
| 210302 | Түлш, халаалт | 441,858,664.83 | 233,643,411.51 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 58,679,528.30 | 58,357,728.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 84,795,680.92 | 48,862,794.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 17,023,580.00 | 18,236,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 1,120,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 10,974,682.97 | 14,785,804.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 10,318,250.00 | 4,700,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 12,452,500.00 | 10,020,490.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 34,026,667.95 | - |
| **2105** | **Нормативт зардал** | 24,475,300.00 | 9,245,950.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 13,375,300.00 | - |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 11,100,000.00 | 9,245,950.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 76,381,045.00 | 65,091,600.00 |
| 210604 | Урсгал засвар | 76,381,045.00 | 65,091,600.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 29,231,225.00 | 21,229,850.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | 13,013,225.00 | 3,000,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 12,618,000.00 | 18,229,850.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 23,761,047.87 | 25,324,541.53 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 23,069,380.86 | 24,828,684.04 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 226,004.00 | 158,684.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 465,663.01 | 337,173.49 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 367,573,682.26 | 326,403,740.09 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,083,422.00 | 26,539,233.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 115,595,387.95 | 69,319,959.20 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 244,894,872.31 | 230,544,547.89 |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| | | | |
|---|---|---|---|
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 52,340,000.00 | 60,535,500.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 52,340,000.00 | 60,535,500.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 1,000,000.00 | 940,500.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 36,825,000.00 | 54,765,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 14,515,000.00 | 4,830,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **314,786,928.35** | **(500,490,506.52)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **314,786,928.35** | **(500,490,506.52)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **2,982,692,711.04** | **2,690,439,965.56** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **2,794,465,711.04** | **2,690,439,965.56** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 2,794,465,711.04 | 2,690,439,965.56 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 2,794,465,711.04 | 2,690,439,965.56 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,482,261,136.00 | 2,406,392,895.70 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 312,204,575.04 | 284,047,069.86 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **188,227,000.00** | - |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 188,227,000.00 | - |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 188,227,000.00 | - |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **3,048,278,514.37** | **2,695,183,811.60** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **3,048,278,514.37** | **2,695,183,811.60** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,995,938,514.37** | **2,635,221,311.60** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,845,958,494.78 | 1,772,782,258.84 |
| 210101 | Үндсэн цалин | 1,845,958,494.78 | 1,772,782,258.84 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 228,030,676.25 | 185,605,303.14 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 228,030,676.25 | 185,605,303.14 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 551,581,385.04 | 393,733,501.89 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 57,680,066.91 | 101,732,362.38 |
| 210302 | Түлш, халаалт | 441,858,664.83 | 233,643,411.51 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 52,042,653.30 | 58,357,728.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 53,967,762.97 | 68,112,794.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 11,522,330.00 | 17,183,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | - | 1,120,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 10,974,682.97 | 14,785,804.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 8,080,000.00 | 3,230,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 10,318,250.00 | 4,700,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 13,072,500.00 | 27,093,490.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 24,475,300.00 | 8,395,950.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 13,375,300.00 | - |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 11,100,000.00 | 8,395,950.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 77,331,045.00 | 63,947,200.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 15,330,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 77,331,045.00 | 48,617,200.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 29,231,225.00 | 21,229,850.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | 13,013,225.00 | 3,000,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 12,618,000.00 | 18,229,850.00 |

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 23,761,047.87 | 24,944,541.53 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 23,069,380.86 | 24,448,684.04 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 226,004.00 | 158,684.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 465,663.01 | 337,173.49 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 161,601,577.46 | 96,469,912.20 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 13,052,422.00 | 32,469,233.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 148,549,155.46 | 64,000,679.20 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **52,340,000.00** | **59,962,500.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 52,340,000.00 | 59,962,500.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 1,000,000.00 | 850,500.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 36,825,000.00 | 54,765,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 14,515,000.00 | 4,347,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **(65,585,803.33)** | **(4,743,846.04)** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **-** | **86,812,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **86,812,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | 86,812,000.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | - | 86,812,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-** | **(86,812,000.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | (65,585,803.33) | (91,555,846.04) |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 165,915,626.72 | 100,329,823.39 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 100,329,823.39 | 8,773,977.35 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | 2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл | 1,074,027,102.40 | 1,323,497,284.11 | 4,474,083,809.46 | 6,871,608,195.97 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | (24,479,535.22) | (424,483,652.78) | (448,963,188.00) |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,074,027,102.40 | 1,299,017,748.89 | 4,049,600,156.68 | 6,422,645,007.97 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | 314,786,928.35 | 314,786,928.35 |
| C08 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,074,027,102.40 | 1,299,017,748.89 | 4,364,387,085.03 | 6,737,431,936.32 |
| D01 | 2025 оны 01-р сарын 01- | 1,074,027,102.40 | 1,299,017,748.89 | 4,679,174,013.38 | 6,737,431,936.32 |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | нээрх үлдэгдэл | | | | |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | (24,479,535.22) | 24,479,535.22 | - |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,074,027,102.40 | 1,274,538,213.67 | 4,388,866,620.25 | 6,737,431,936.32 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | (500,490,506.52) | (500,490,506.52) |
| D09 | 2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,074,027,102.40 | 1,274,538,213.67 | 3,888,376,113.73 | 6,236,941,429.80 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **4,514,661,334.00** | **2,781,995,811.60** | **1,732,665,522.40** | 61.6 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 4,371,661,334.00 | 2,695,183,811.6 | 1,676,477,522.4 | 61.7 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 4,304,696,334.00 | 2,635,221,311.60 | 1,669,475,022.4 | 61.2 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 2,990,988,030.00 | 1,772,782,258.84 | 1,218,205,771.2 | 59.3 |
| 210101 | Үндсэн цалин | 2,990,988,030.00 | 1,772,782,258.84 | 1,218,205,771.2 | 59.3 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 240,130,475.00 | 185,605,303.14 | 54,525,171.9 | 77.3 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 240,130,475.00 | 185,605,303.14 | 54,525,171.9 | 77.3 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 671,416,265.00 | 393,733,501.89 | 277,682,763.1 | 58.6 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 110,000,000.00 | 101,732,362.38 | 8,267,637.6 | 92.5 |
| 210302 | Түлш, халаалт | 451,416,265.00 | 233,643,411.51 | 217,772,853.5 | 51.8 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 110,000,000.00 | 58,357,728.00 | 51,642,272.0 | 53.1 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 90,532,340.00 | 68,112,794.00 | 22,419,546.0 | 75.2 |
| 210401 | Бичиг хэрэг | 19,980,000.00 | 17,183,500.00 | 2,796,500.0 | 86.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 7,292,860.00 | 1,120,000.00 | 6,172,860.0 | 15.4 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 15,583,640.00 | 14,785,804.00 | 797,836.0 | 94.9 |
| 210404 | Ном, хэвлэл | 10,869,800.00 | 3,230,000.00 | 7,639,800.0 | 29.7 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 4,411,500.00 | 4,700,000.00 | (288,500.0) | 106.5 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 32,394,540.00 | 27,093,490.00 | 5,301,050.0 | 83.6 |
| **2105** | **Нормативт зардал** | 29,412,440.00 | 8,395,950.00 | 21,016,490.0 | 28.5 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 19,412,440.00 | - | 19,412,440.0 | 0.0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 10,000,000.00 | 8,395,950.00 | 1,604,050.0 | 84.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 64,553,500.00 | 63,947,200.00 | 606,300.0 | 99.1 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 15,553,500.00 | 15,330,000.00 | 223,500.0 | 98.6 |
| 210604 | Урсгал засвар | 49,000,000.00 | 48,617,200.00 | 382,800.0 | 99.2 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 29,258,000.00 | 21,229,850.00 | 8,028,150.0 | 72.6 |
| 210701 | Гадаад албан томилолт | 5,000,000.00 | 3,000,000.00 | 2,000,000.0 | 60.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 24,258,000.00 | 18,229,850.00 | 6,028,150.0 | 75.1 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 24,823,584.00 | 24,944,541.53 | (120,957.5) | 100.5 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 24,562,100.00 | 24,448,684.04 | 113,416.0 | 99.5 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 158,684.00 | 158,684.00 | - | 100.0 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 102,800.00 | 337,173.49 | (234,373.5) | 328.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 163,581,700.00 | 96,469,912.20 | 67,111,787.8 | 59.0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 34,026,000.00 | 32,469,233.00 | 1,556,767.0 | 95.4 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 129,555,700.00 | 64,000,679.20 | 65,555,020.8 | 49.4 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 66,965,000.00 | 59,962,500.00 | 7,002,500.00 | 89.5 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 66,965,000.00 | 59,962,500.00 | 7,002,500.0 | 89.5 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | - | 850,500.00 | (850,500.0) | |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 54,765,000.00 | 54,765,000.00 | - | 100.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 12,200,000.00 | 4,347,000.00 | 7,853,000.0 | 35.6 |

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **143,000,000.00** | **86,812,000.00** | **56,188,000.0** | 60.7 |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 143,000,000.00 | 86,812,000.00 | 56,188,000.0 | 60.7 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 123,000,000.00 | 86,812,000.00 | 36,188,000.0 | 70.6 |
| 223001 | Бусад хөрөнгө | 20,000,000.00 | - | 20,000,000.0 | 0.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **3,748,447,804.00** | **2,690,439,965.56** | **1,058,007,838.4** | 71.8 |
| **120004** | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 3,748,447,804.00 | 2,690,439,965.56 | 1,058,007,838.4 | 71.8 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,353,542,800.00 | 2,406,392,895.70 | 947,149,904.3 | 71.8 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 309,000,000.00 | 284,047,069.86 | 24,952,930.1 | 91.9 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 85,905,004.00 | - | 85,905,004.0 | 0.0 |

## ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 30,354.0 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа [1] -г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

### 3.1 Залруулсан алдаа:

- **Мэдээллийг орхигдуулсантай холбоотой:** Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 11,412,231.9 мянган төгрөгийн 90 мэдээллээс, бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийн 30,354.0 мянган төгрөгийн 9 мэдээллийг мэдээлээгүйг нөхөн байршууллаа.

Залруулагдаагүй нийт 86,812.0 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Нийт 86,812.0 мянган төгрөгийн 2 зөрчил[2] илэрсэнд зөвлөмж хүргүүлсэн.

### 3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**Нэг. Орлогын бүрдүүлэлт, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой**

Илрүүлэлт: Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 3,662,542.8 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлэхээр төлөвлөсөн болович 972,102.8 мянган төгрөгөөр

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

тасарсан байна. Үүнд Боловсролын зээлийн сангаас санхүүжих 785,515.8 мянган төгрөгийн орлого байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-т "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх", 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Орлогыг бодитоор тооцоолж, гүйцэтгэлийг хангаж ажиллах.

Илрүүлэлт: Байгууллагад нам даралтын зуух худалдан авахад 86,812.0 мянган төгрөг зарцуулсан боловч сонгон шалгаруулалт зохион байгуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т "Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно", гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Босго үнээс давсан төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ хуулийн дагуу худалдан авах ажиллагаа зохион байгуулж байх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тайлан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

*4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл* *(мянган төгрөгөөр)*

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Алдааны утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс: | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | тоо | Дүн | тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 |
| АШУҮИС-ийн Говь-Алтай аймаг дахь салбар Анагаах ухааны сургууль | Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 11,412,231.9 мянган төгрөгийн 90 мэдээллээс, бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийн 30,354.0 мянган төгрөгийн 9 мэдээллийг мэдээлээгүй байна. | 1 | 30,354.0 | 1 | 30,354.0 | - | - | 1 | 30,354.0 | - | - | - | - |
| **Дүн** | | **1** | **30,354.0** | **1** | **30,354.0** | **-** | **-** | **1** | **30,354.0** | **-** | **-** | **-** | **-** |

## Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

*4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл* *(мянган төгрөгөөр)*

| **Аудитад хамрагдсан байгууллагын нэр** | **Алдаа, зөрчлийн товч утга** | **Нийт алдаа, зөрчлийн дүн** | | **Үүнээс:** | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | **Тоо** | **Дүн** | **Төлбөрийн акт** | | **Албан шаардлага** | | **Зөвлөмж** | | **Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн** | |
| | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| АШУҮИС-ийн Говь-Алтай аймаг дахь салбар Анагаах ухааны сургууль | Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 3,662,542.8 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлэхээр төлөвлөсөн боловч 972,102.8 мянган төгрөгөөр тасарсан байна. Үүнд Боловсролын зээлийн сангаас санхүүжих 785,515.8 мянган төгрөгийн орлого байна. | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Байгууллагад нам даралтын зуух худалдан авахад 86,812.0 мянган төгрөг зарцуулсан боловч худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй. | 1 | 86,812.0 | | | | | 1 | 86,812.0 | | |
| **Дүн** | | 2 | 86,812.0 | - | - | - | - | 2 | 86,812.0 | - | - |

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Өөрчлөлтгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | | 1 | | | | 1 | | |
| | НИЙТ | | 1 | | | | 1 | | |



Говь-Алтай аймаг дахь
ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАР